

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл

Иж бүрэн цөмийн аюулгүй байдлын баталгааны гэрээнд (Comprehensive Safeguards Agreement) Монгол Улс 1972 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр нэгдэн орсон. Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээний баталгааг хэрэглэх тухай Нэмэлт протоколд Монгол Улс нэгдэн орж, 2001 оны 12 дугаар сард гарын үсэг зурсан бөгөөд Монгол Улсын Их Хурал 2003 онд соёрхон баталсан. Улмаар Олон Улсын Атомын Энергийн Агентлагт 2003 оны 05 дугаар сарын 12-ны өдөр мэдэгдэж, энэ өдрөөс протоколыг хучин төгөлдөр мөрдөж байна.

Олон Улсын Атомын Энергийн Агентлаг ("ОУАЭА") нь Цөмийн аюулгүй байдлын "Иж бүрэн аюулгүй байдлын баталгааны гэрээ" ба Нэмэлт протоколыг хэрэгжүүлж буй улс орнуудын бүх цөмийн материал энхийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа эсэх өргөн хэмжээний албан ёсны дүгнэлтийг гаргадаг.

ОУАЭА-ийн Удирдах зөвлөлөөс цөмийн байгууламжгүй, бага хэмжээний цөмийн материалтай улс орнуудад "Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протокол"-д хамрагдах нь зүйтэй гэж үзэн гишүүн орнуудыг тус Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн орохыг уриалсан. Үүний дагуу ОУАЭА-аас манай улсыг Бага хэмжээний цөмийн материалын протоколд нэгдэн орох саналыг 2005 оны 12 дугаар сарын 14-ний өдөр ирүүлсэн ч манай улс нэгдэн орох асуудал өнөөдрийг хүртэл шийдэгдээгүй байна.

2005 онд ОУАЭА-ийн Удирдах зөвлөлийн шийдвэр гарснаас хойш багагүй хугацаа өнгөрснийг харгалzan ОУАЭА нь Бага хэмжээний цөмийн материалын протоколын анхны хувилбартай байгаа улс орнуудад баталгааны дүгнэлтийг цаашид үргэлжлүүлэн гаргах боломжгүй болохыг мэдэгдсэн тул Монгол Улс ойрын хугацаанд зохих арга хэмжээ авахгүй тохиолдолд 2024 оноос эхлэн ОУАЭА-аас баталгааны дүгнэлт гаргуулах боломжгүй болох эрсдэл үүсээд байна.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 06 дугаар сарын 19-ны өдөр баталсан "Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай" 60 дугаар тогтоолд Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн орохыг Засгийн газарт даалгасан ба тус тогтоолыг хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг Улсын Их Хурлаар соёрхон батлуулах талаар хэлэлцэн дэмжиж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр шийдвэрлэсэн.

Улмаар Засгийн газраас тус конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд зөвшилцөхөөр хүргүүлсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаар конвенцод нэгдэн орох асуудлыг хэлэлцээд дэмжсэн санал, дүгнэлт гарсан.

2024 оны Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дараа Монгол Улсын Засгийн газар шинэчлэн байгуулагдсантай холбоотойгоор хуулийн төслийн үзэл баримтлалыг шинэчлэн батлуулж, Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11

чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 79.1-д заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу өргөн мэдүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

**Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг
соёрхон батлах тухай хуулийн төсөл**

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 06 дугаар сарын 19-ны өдөр баталсан “Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай” 60 дугаар тогтоолын 3 дахь хэсэгт “Цөмийн аюулгүй байдлын тухай 1994 оны конвенц, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцийн 2005 оны нэмэлт, өөрчлөлтийн тухай протокол болон **Цөмийн бага хэмжээний шинэчилсэн протоколд** тус тус нэгдэн орох” арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Иймд, Монгол Улсын Улсын Их Хурлын 2015 оны 60 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор энэхүү хуулийн төслийг боловсруулав.

1. Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлага

Монгол Улс Иж бүрэн цөмийн аюулгүй байдлын баталгааны гэрээнд (Comprehensive Safeguards Agreement) 1972 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр нэгдэн орсон. Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээний баталгааг хэрэглэх тухай Нэмэлт протоколд Монгол Улс нэгдэн орж, 2001 оны 12 дугаар сард гарын үсэг зурсан бөгөөд Улсын Их Хурал 2003 онд соёрхон баталж, Олон Улсын Атомын Энергийн Агентлаг (“ОУАЭА”)-т 2003 оны 05 дугаар сарын 12-ны өдөр мэдэгдэж, энэ өдрөөс протоколыг хүчин төгөлдөр мөрдөж байна.

2024 оны 09 дүгээр сарын байдлаар ОУАЭА-ийн “Иж бүрэн цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх баталгааны гэрээ”-нд 191 орон, “Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протокол”-д (Small Quantity Protocol) 63 улс протоколын шинэчилсэн хувилбарыг даган мөрдөж байна.

Иж бүрэн баталгааны гэрээ нь заавал дагаж, мөрдөх гэрээ бөгөөд гэрээний хүрээнд цөмийн материалыг цөмийн зэвсэг эсвэл бусад тэхөөрөмжийд ашиглахгүй байх, цөмийн тэхөөрөмжтэй болон тэхөөрөмжгүй улсууд адил шаардлагын дагуу цөмийн материалын бүртгэл, хяналтын тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, ОУАЭА-т тайлан, мэдэгдэл хүргүүлэх зэрэг үүрэг хүлээдэг.

Бага хэмжээний цөмийн материалын протоколын анхны хувилбарын зарим хийдлүүдийг арилгах үүднээс цөмийн байгууламжгүй, бага хэмжээний цөмийн материалын протоколтой улс орнуудад зориулан Олон улсын атомын энергийн агентлаг нь 1974 онд баталсан Бага хэмжээний цөмийн материалын протоколын анхны хувилбарыг 2005 онд шинэчилсэн.

Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд манай улс нэгдсэн орсноос хойш Баталгаанд хамаарах бүх цөмийн материалын анхны тайланг 30 хоногийн дотор ОУАЭА-т хүргүүлэх үүрэгтэй бөгөөд цаашид тайлангаа шинэчлэн, цөмийн материалын өөрчлөлт, шилжилт хөдөлгөөний талаарх мэдээлэл, экспорт, импортын тухай тайланг жил хүргүүлж байх үүрэгтэй.

ОУАЭА-ийн Удирдах зөвлөлөөс цөмийн байгууламжгүй, бага хэмжээний

шинэчилсэн протокол"-д хамрагдах нь тохиромжтой гэж үзэн гишүүн орнуудыг элсэн орохыг уриалсан. Үүний дагуу Олон улсын атомын энергийн агентлагаас манай улсыг Бага хэмжээний цөмийн материалын протоколд нэгдэн орох уриалгыг 2005 оны 12 дугаар сарын 14-ний өдөр ирүүлсэн ч нэгдэн орох асуудал өнөөдрийг хүртэл шийдгээгүй байна.

Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотод 2024 оны 9 дүгээр сарын 16-20-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Олон Улсын Атомын Энергийн Агентлагийн Ерөнхий бага хурлын ээлжит 68 дугаар чуулганаар Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх баталгааны газраас гаргасан хүсэлтийн дагуу манай улсын төлөөлөгчид уулзалт хийсэн. ОУАЭА-аас Монгол Улсыг Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн ороогүй цөөн орны тоонд багтсан бөгөөд протоколыг даруй шинэчлэх шаардлагатайг дахин анхааруулж, 2024 онд багтаан протоколыг шинэчлэх шаардлагатайг мэдэгдсэн.

Улмаар ОУАЭА-ийн Ерөнхий захирлын орлогч бөгөөд Баталгааны газрын дарга Массимо Аппарогийн 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн албан захидалыг Цөмийн энергийн комиссын дарга, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваанд ирүүлсэн бөгөөд тус захидалд ОУАЭА-ийн Захирлуудын зөвлөлийн шийдвэр 2005 онд гарснаас хойш багагүй хугацаа өнгөрснийг харгалзан ОУАЭА нь Бага хэмжээний цөмийн материалын протоколын анхны хувилбартай байгаа улс орнуудад баталгааны дүгнэлтийг үргэлжлүүлэн гаргах боломжгүй тул Монгол Улсын Засгийн газар зохих арга хэмжээ авахгүй тохиолдолд баталгааны дүгнэлт гаргах боломжгүй болохыг мэдэгдсэн. Энэ нь Монгол Улсын нэр хүнд олон улсад болон ОУАЭА-т буурах, Монгол Улсад хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр болон бусад дэмжлэг, тусламжийг царцаах сөрөг үр дагавар үүсээд байна.

Монгол Улс нь цөмийн байгууламжгүй бөгөөд бага хэмжээний цөмийн материалтай улсын хувьд Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн орох нь өөрийн улсын онцлог, нөхцөл байдалд тохирсон цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааг хэрэгжүүлэх, улмаар цөмийн материалын ашиглалт, хэрэглээнд үр дүнтэй хяналт тавих, цөмийн аюулгүй байдлын баталгааг гүйцэтгэх, хяналтын техникийн чадавхыг бэхжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, цөмийн материалын хяналтын тооллогын улсын системийг бий болгох чиглэлээр ОУАЭА-аас зөвлөх үйлчилгээ авах, дадлагажуулах хөтөлбөрт хамрагдах зэрэг олон талын ач холбогдолтой.

2. Конвенцын зорилго, зохицуулах зүйл, хамрах хүрээ

Эрүүл мэнд, аж үйлдвэрийн салбарт цацраг идэвхт үүсгүүрийн хэрэглээ нэмэгдэж байгаатай холбогдуулан цөмийн материалын тоо хэмжээ нэмэгдэх магадлалтай байна. Цөмийн материалын эрүүл мэндийн салбар дахь түгээмэл хэрэглээ нь хавдрын зайн туяа эмчилгээний тоног төхөөрөмжийн цацрагийн хамгаалалтад ядуурсан ураныг ашиглах явдал юм. Цөмийн материал нь мөн аж үйлдвэр, судалгаа шинжилгээний зорилгоор ашиглагддаг.

Олон улсын атомын энэргийн агентлаг нь Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээний "Баталгааны хэлэлцээр" ба Нэмэлт протоколыг хэрэгжүүлж буй улс орнуудын бүх цөмийн материал энхийн үйл ажиллагаанд ашиглагдаж буйг дүгнэсэн өргөн хэмжээний дүгнэлтийг гаргадаг.

Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд манай улс нэгдсэн орсноос хойш Баталгаанд хамаарах бүх цөмийн материалын анхны тайланг 30 хоногийн дотор ОУАЭА-т хүргүүлэх үүрэгтэй бөгөөд цаашид тайлангаа шинэчлэн, цөмийн материалын өөрчлөлт, шилжилт хөдөлгөөний талаарх мэдээлэл, экспорт, импортын тухай тайланг жил хүргүүлж байх үүрэгтэй болох юм.

Цөмийн материалын байршил, шинж чанарын талаар мэдээлэл өгөх анхны тайланг ОУАЭА-ийн маягтын дагуу гаргана. Хэрэв тухайн улс нь өөрийн нутаг дэвсгэрт ямар нэгэн цөмийн материал байхгүй гэж тодорхойлсон бол энэ талаар ОУАЭА-т мөн мэдээлэх үүрэгтэй.

Хэрэв тайлан хүргүүлснээс хойш тухайн улсад цөмийн материал тодорхойлогдсон тохиолдолд тайланг дараагийн шатанд засварлах боломжтой. Анхны тайланг хүргүүлсний дараагаар бүртгэлд ямар нэгэн өөрчлөлт орсон бол тухайн улс нь ОУАЭА-ийг хамгийн бацадаа жил бүр шинэчилсэн мэдээллээр хангаж байх үүрэгтэй. Хэрэв өөрчлөлт ороогүй тохиолдолд анхны тайландаа нэмэлт хүргүүлэх шаардлагагүй.

3. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй бөгөөд 1 дүгээр зүйлд Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай гэрээтэй холбогдуулан Монгол Улс болон Олон Улсын Атомын Энергийн Агентлаг хооронд 1972 онд байгуулсан Баталгааны хэлэлцээрийн Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах зохицуулалтыг тусгав.

4. Хуулийн төсөл батлагдсанаар хүлээгдэж буй үр дүн

Цөмийн материалыг энхийн зорилгоор ашиглах үйл ажиллагаанд олон улсын байгууллагын хөндлөнгийн хяналт хийгдэж, аюулгүй байдлын түвшин дээшилнэ.

Бага хэмжээний хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн орсон улс орнууд Олон улсын атомын энергийн агентлагаас томилсон хяналт, шалгалтын байцаагч нарын томилгоог хүлээн авах, шаардлагатай тохиолдолд хил нэвтрэх эрх олгох, эрхийг шинэчлэх зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, анхны тайландаа тодорхойлсон байршил болон цөмийн материалын байршилд нэвтрэх эрхийг бүрэн олгох үүрэгтэй.

Мөн Иж бүрэн баталгааны гэрээний дагуу тухайн улс орон Олон улсын атомын энергийн агентлаг болон түүний хяналт, шалгалтын үүрэг гүйцэтгэж буй байцаагч наарт “Олон улсын атомын энергийн агентлагийн халдашгүй дархан эрхийн тухай гэрээ”-ний холбогдох заалтуудад тусгасан давуу эрх, халдашгүй байдлыг хангах үүрэгтэй.

Монгол Улс нь цөмийн байгууламжгүй бөгөөд бага хэмжээний цөмийн материалтай улсын хувьд Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн орох нь өөрийн онцлог, нөхцөл байдалд тохирсон цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааг хэрэгжүүлэх, улмаар цөмийн материалын ашиглалт, хэрэглээнд үр дүнтэй хяналт тавих, цөмийн аюулгүй байдлын баталгааг гүйцэтгэх, хянах техникийн чадавхыг бэхжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, цөмийн материалын хяналтын тооллогын улсын системийг бий болгох чиглэлээр ОУАЭА-

ийн зөвлөх үйлчилгээ авах, дадлагажуулах хөтөлбөрт хамрагдах зэрэг олон талын ач холбогдолтой юм.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР